



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 02 сарын 09 өдөр

Дугаар 40

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн “Ховд АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн 2021 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар 118.3 (нэг зуун арван найман сая гурван зуу) сая төгрөгийн зөрчил, дутагдал илэрснийг тэмдэглээд ТОГТООХ нь:

1. “Ховд АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны А-1/66 дугаартай албан даалгаврын биелэлтээр 95.4 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” байх тул дотоод хяналтыг сайжруулж дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг “Ховд АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн Гүйцэтгэх захирал (Б.Батцагаан)-д үүрэг болгосугай.

2.1. Шалгалтын тайланд дурдсан зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллах;

2.2. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас баталсан эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшингийн төлөвлөгөөг үзүүлэлт бүрээр ханган биелүүлэх;

2.3. Компанийн санхүүгийн тайланд борлуулах зорилготой хөрөнгөөр бүртгэсэн, 36.5 сая төгрөгийн балансын үнэ бүхий тээврийн хэрэгслийн гэрчилгээг шилжүүлэн авч хөрөнгийг эдийн засгийн эргэлтэд оруулах асуудлыг хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлүүлэх талаар зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

2.4. “Ховд АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн хариуцаж байсан Ховд-Булган чиглэлийн Бага улаан даваанаас улсын хил хүртэлх 236 км замыг “Өсөн дэвжих зам” ХХК-д шилжүүлсэн тул Мөст сумын Бага улаан давааны болон Булган суман дахь өвлийн шуурхайн байрны ашиглалтыг сайжруулах талаар санал боловсруулж эрх бүхий байгууллагад хүргүүлэн шийдвэрлүүлэх;

2.5. “Зам, тээврийн хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газраас хүлээлгэн өгсөн үнэ, үнэлгээ тодорхойгүй, цас цэвэрлэгээний болон нөхөөсний зориулалттай, 2 ширхэг тусгай зориулалт бүхий тээврийн хэрэгслийг санхүүгийн тайланд үнэлж бүртгэх талаар Зам, тээврийн хөгжлийн яам, Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүсэлт тавьж шийдвэрлүүлэх;

132001147
3-r huraldaan.docx

2.6.Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй бараа, ажил, үйлчилгээ худалдан авахгүй байх, үйл ажиллагаандаа “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”, Сангийн сайдын 2021 оны 102 дугаар тушаалаар баталсан “Худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ыг мөрдөн ажиллах;

2.7.Тогтоолын биелэлтийг 2023 оны 2 дугаар улиралд, өссөн дүнгээр 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах талаар бодиттой, үр дүнтэй арга хэмжээг авч хэрэгжүүлэх, санхүүгийн сахилга батыг хэвшүүлэн ажиллах.

4.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.ТҮВШИНЗАЯА



Ц.Түвшинзаяа



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 02 дугаар сарын 09-ны өдрийн
02 дугаар тогтоолын хавсралт

“Ховд АЗЗА” төрийн өмчит компанид хийсэн
шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах
арга хэмжээний жагсаалт

Д/д	Зөрчил дутагдлын утга	Мөнгөн дүн /сая төгрөгөөр/	Зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалт
1	Үргүй зардал санхүүжүүлсэн.	81.8	Гүйцэтгэх захиралтай байгуулсан гэрээний үүргийн хэрэгжилтийг ханган ажиллах, компанийн хөрөнгө, эд хариуцагчийг хариуцлагын болон эд хөрөнгийн даатгалд хамруулах асуудлыг шийдвэрлэх.
2	Хөрөнгийн эзэмшилт, ашиглалтыг байдалд хяналт тавьж ажиллах.	36.5	Тээврийн хэрэгслийн гэрчилгээг компанийн нэр дээр шилжүүлэн, хөрөнгийн ашиглалтыг сайжруулах арга хэмжээ авах.
	НИЙТ ДҮН:	118.3 (Нэг зуун арван найман сая гурван зуу)	

-----oOo-----